

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлаас 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль анхлан боловсруулахдаа “Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн төсөл нэртэйгээр боловсруулагдаж өргөн мэдүүлэгдсэн байдаг. Улмаар тус хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад “аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл”-тэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан заалт, зохицуулалтыг хасаж, хууль нь зөвхөн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаанд үйлчлэхээр баталсан байдаг.

Зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн нөхцөлд аж ахуй эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан дэмжих үүднээс төрийн зохицуулах хийх тохиолдолд нэгдмэл, цэгцтэй зохицуулалт хийх, үүнтэй холбогдох төрийн захиргааны бүх шатны байгууллагаас аж ахуйн нэгжтэй харилцах харилцаанд шинэчлэл хийж, хүнд суртал чирэгдэлгүй уян хатан үйлчлэх, нөгөө талаас үндэсний аюулгүй байдал, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэх зорилгоор тус хуулийг боловсруулсан талаар хуулийн төслийн танилцуулгад дурдсан байдаг.¹

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төслийн хувийн хэрэгт “Аж ахуйн үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд төрийн янз бүрийн шатны байгууллагаас бүртгэх, зөвшөөрөл олгох, хяналт тавих шалгалт хийх нүсэр тогтолцоо үйлчилж байгаа нь эдийн засгийн хөгжил, гадаад, дотоод хөрөнгө оруулалтад ноцтой саад тотгор болж байна. Бүртгэл зөвшөөрлийн журмыг хууль, Засгийн гзрын тогтоол, яам, тусгай газрын тушаал, орон нутгийн захиргаад, Иргэдийн тэргүүлэгчдийн Хурал зэрэг олон шатны байгууллагын эрхийн актаар тогтоон мөрдүүлж байна.” гэж дурдаад дээрх нөхцөл байдлыг өөрчилж, аж ахуй эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан дэмжих үүднээс тус хуулийг баталсан байдаг.

Өөрөөр хэлбэл нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах үүднээс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр баталж, 2002 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төслийн хувийн хэрэг, IV боть, 168 тал, 2001 он

нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж тус тус заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, хувийн аж ахуй эрхлэх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх зэрэг эрхийг Монгол Улсын иргэн баталгаатай эдлэхээр тунхагласан ба Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заажээ.

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.” гэж, мөн зүйлийн 26.8 дахь хэсэгт “Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ.” гэж, 189 дүгээр зүйлийн 189.2 дахь хэсэгт “Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно.” гэж, мөн зүйлийн 189.3 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.” гэж тус тус хуульчилжээ.

Монгол Улсын Үндсэн хууль хийгээд Иргэний хуулийн дээрх суурь зарчим, зохицуулалт, үзэл санааг бэхжүүлэхэд тус хууль нь тодорхой хэмжээнд үүргээ гүйцэтгэж байна.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай

газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна.” гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалт нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй харилцаанаас бусад харилцаанд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг тус хуулиар төрөлжүүлэн зохицуулахаар заасныг илтгэж байна.

Гэвч зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаа нь өнөөдрийн байдлаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын шинжтэй 100 гаруй хуулиар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох харилцаа ямар нэг хэмжээнд зохицуулагдаж байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль нь батлагдах явцад **11 чиглэлээр 78 төрөл /зарим төрөл нь хэд хэдэн үйл ажиллагааг хамруулж байсан/-ийн тусгай зөвшөөрөл олгохоор байсан хэдий ч** хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш хугацаанд уг хуульд 69 удаа нэмэлт, өөрчлөлт орж, тусгай зөвшөөрлийн чиглэл, төрөл нэмэгдсэн төдийгүй нэр томьёоны зөрчил үүсэх, зарим талаараа хуулийн уялдаа холбоо алдагдахад хүргэсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын шинжтэй бусад хуулиар бий болгоогүй зөвшөөрлийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар бий болгох буюу задлан олшруулах хууль зүйн практик ч мөн тогтсон байна.

Өнөөдрийн байдлаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд 19 чиглэлээр 103 ерөнхий төрөл, энэхүү төрөл нь 210 гаруй дэд төрөлд хуваагдан тусгай зөвшөөрөл олгохоор байгаа боловч салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн дэд актаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл /олон удаа болон нэг удаагийн шинжтэй/-ийг шинээр бий болгох, ерөнхий төрлийг задалж олгох байдал түгээмэл болсон байна.

Өөрөөр хэлбэл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй зөвшөөрлийн чиглэл, төрлөөр зөвшөөрөл олгох харилцаа явагдаж байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2016 оны байдлаар 54 байгууллага 914 төрлийн зөвшөөрөл олгож байна гэсэн судалгаа хийгдсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугар тогтоолд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуультай уялдуулан хянан үзэж, тодорхой санал

боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаатай үүрэг Засгийн газарт өгөгдсөн ч одоог болтол бүрэн хэрэгжээгүй байна.

Монгол Улсын хэмжээнд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл буюу тодорхой үйл ажиллагааг эрхлэхээр эрх олгосон, тэдгээртэй холбоотой нэгдсэн мэдээллийн сан байхгүй байгаа бөгөөд зөвшөөрөл олгож байгаа байгууллага бүр мэдээллийн дэд сан үүсгэн явуулж байгаа практик нэлээдгүй байна.

Түүнчлэн мэдээллийн сан үүсгэх, ямар мэдээллийг оруулах, лавлагаа мэдээллийн хэрхэн өгөх асуудал зарим талаараа зохицуулалтын хувьд тодорхой бус байна.

Мөн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтад зааснаар жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх чиг үүргийг хүлээж байгаа боловч энэ чиглэлээр хийсэн ажил, үр дүн тодорхой бус байна.

Иймд зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр олгосон нэг удаагийн болон олон удаагийн шинжтэй бүх зөвшөөрлийн бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан зөвшөөрлийн цахим нэгдсэн сантай байх ба зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бий болгох шаардлага байна.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хууль хийгээд Иргэний хуулийн суурь зохицуулалтад нийцүүлэх, түүнчлэн өнөөгийн нийгэм, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг бүхэлд нь шинэтгэх шаардлага тулгараад байна.

Хоёр.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ

2.1.Үнэлгээ хийх шалтгаан

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 16 жилийн хугацаанд хуулийн практик хэрэгжилтэнд тодорхой бэрхшээл үүссэн төдийгүй, шаардлагатай чухал асуудлууд ч өнөөг хүртэл зохицуулалтгүй явж ирсэн, түүнчлэн бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлэх, хүчинтэй байх хугацааг уртасгах, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тусгай зөвшөөрөл олгох харилцааг хөнгөн шуурхай болгох, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тогтоох зорилтыг хангах үүднээс тус хуулийн холбогдох зохицуулалт, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлага үүссэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн² 2-т зөвшөөрөл, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийг боловсруулахаар тогтсон болно.

2.2. Үнэлгээний зорилго:

Үнэлгээ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 51 дүгээр зүйлд заасны дагуу Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох заалт, зохицуулалатын хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, улмаар уг харилцааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын хувилбарыг тогтоох зорилготой болно.

2.3. Үнэлгээний хүрээ

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид Аргачлал гэх/-ын дагуу гүйцэтгэсэн.

Аргачлалын заасны дагуу үнэлгээний хүрээнд тус хуульд хэсэгчилсэн байдлаар үнэлгээ хийхээр тогтоолоо.

Түүнчлэн тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн харилцааг нийгмийн амьдралд өргөн хүрээний нөлөөлөл үзүүлж, нийгэм, эдийн засаг, бусад харилцаа хурдтай өөрчлөлтөөс хамааран Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиас гадна салбарын бусад хуулиар зохицуулж байна.

Иймд үнэлгээний хүрээнд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлийн харилцааг зохицуулсан холбогдох бусад хуулийн тодорхой зохицуулалтыг давхар хамруулсан болно.

2.4. Шалгуур үзүүлэлт ба харьцуулах хэлбэр

Аргачлалын 3.4, 3.5, 3.6-д заасны дагуу хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэхдээ хамрах хүрээ болон шалгуур үзүүлэлт, түүний томъёоллыг дараахь байдлаар тогтоож байна:

² Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 111-ний өдрийн 11 дүгээр тогтоол

Үнэлгээний хүрээ		Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Харьцуулах хэлбэр
1	1, 2 дугаар зүйл	Зорилгод хүрсэн түвшин	Хуулийн зорилтыг хангаж чадаж байна уу?	Байх ёстой болон одоо байгаа
2	5.2, 9.1, 15, 16 дугаар зүйл	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн зохицуулалтууд хэрэгжиж байна уу? Хэрэв хэрэгжилт сул бол шалтгаан юунд байна?	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
3	18 дугаар зүйл	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Гэмт хэрэг, зөрчилд тооцсон үйлдэл, эс үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлага оновчтой байна уу?	Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль үйлчилж эхлэхээс /2017-07-1/ өмнө болон хойш

- **Зорилгод хүрэх түвшин** шалгуур үзүүлэлтээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх дэвшүүлсэн зорилгын дагуу энэ төрлийн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтооно.
- **Практикт нийцэж байгаа байдал** шалгуур үзүүлэлтээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой гарч байгаа эерэг, сөрөг үр дагаварыг илрүүлж, улмаар түүнийг үүсгэж байгаа учир шалтгааныг тодорхойлно.
- **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** шалгуур үзүүлэлтээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуулиар оновчтой тогтоосон эсэх, түүний үр нөлөөг тодорхойлно.

Энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэх зорилгоор 2002 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, энэ чиглэлээр хийгдсэн төрийн болон ТББ-ын судалгаа, төрийн холбогдох байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн болон статистик тоон мэдээлэл зэргийг цуглуулсан болно.

Гурав.Үнэлгээний тайлан

3.1.Зорилгод хүрэх түвшин:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн зорилт нь тухайн хуулийн, хууль тогтоогчийн хүсэж буй зорилгод хүрэхийн тулд шат дараалан, эсхүл давтан хэрэгжүүлж байгаа арга хэмжээ буюу давтан зохицуулах харилцааг илтгэж байдаг ба Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зорилт нь **нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд** хохирол учруулж болзошгүй, **тодорхой нөхцөл, нарийн мэргэжил** шаардах аж ахуйн **зарим** үйл ажиллагааг эрхлэхэд **тусгай зөвшөөрөл** олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна.

Дээрх тодорхойлолтоос авч үзвэл:

-нийтийн ашиг сонирхол;

-хүний эрүүл мэнд;

-хүрээлэн байгаа орчин;

-улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахаар заасан хэдий ч байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмч³ буюу ашигт малтмал⁴, газрын тос,⁵ уламжлалт бус газрын тос,⁶ үүсмэл орд,⁷ түгээмэл тархацтай ашигт малтмал⁸-ыг ашиглахад тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэхээр тус хуулийн 15 дугаар зүйлд тусгасан байна.

Нөгөө талаараа ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмал, газрын тос ашиглах үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа орчинд тодорхой хэмжээгээр хохирол учруулдаг ба дээрх байгалийн баялагийн ашиглах тусгай зөвшөөрөл буюу байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглах эрх нь тус хуулийн зорилтод тусгагдсан нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт хамааруулж авч үзэх талтай юм.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай,

³ Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

⁴ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.6 дахь заалт

⁵ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.20 дахь заалт

⁶ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.21 дэх заалт

⁷ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.22 дахь заалт

⁸ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16.2.7 дахь заалт

Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна.” гэж заасан нь **хүрээлэн байгаа орчинд** хохирол учруулж болзошгүй аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах хуулийн зорилттой зөрчилдсөн гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуультай уялдуулан хянан үзэж, тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаатай үүрэг Засгийн газарт өгөгдсөн байгаа нь хууль тогтоогчийн зүгээс тусгай зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг харилцааг цаашид төрөлжүүлэн нэгтгэж, нэг хуулиар зохицуулах бодлого баримталж байсныг илтгэж байна. Гэхдээ Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоол одоог хүртэл хэрэгжээгүй бөгөөд харин ч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заагдаагүй зөвшөөрлийг бусад төрлийг бусад хуулиар нэмэгдүүлэх байдал хавтгай болсон байна.

Түүнчлэн хуулийн зорилтод тусгагдсан “тодорхой нөхцөл ...шаардах үйл ажиллагаа” гэдэгт ямар үйл ажиллагааг хамааруулж ойлгож ирсэн, ойлгох нь тодорхой бус бөгөөд энэхүү хуулийн зорилт хангагдаж байгаа гэж дүгнэх боломжгүй байна.

Мөн хуулийн зорилт нь аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахаар заасан боловч хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт хориглох аж ахуйн үйл ажиллагаа төрлийг тогтоосон, тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөл олгох байгууллагын бүрэн эрх зэрэг хуулийн зорилтод тусгагдаагүй зарчмын асуудлыг хуульчилсан байгаа хуулийн зорилтыг оновчтой томъёолсон гэж үзэх боломжгүйг харуулж байна.

Хуулийн нэр хийгээд хуулийн зорилтод тусгаж хэрэглэсэн “тусгай зөвшөөрөл” гэх ойлголт хэт явцуу байдалтай байгаа бөгөөд өнөөдөр практикт зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх эрхийг зохих эрх бүхий байгууллагаас олгож байгааг баталгаажуулсан, эсхүл энэхүү эрхийг олгох урьдчилсан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхийг нотолсон баримт бичгүүд болох, нэршлийн хувьд дүгнэлт, зөвшөөрөл, шийдвэр, гэрчилгээ, сертификат, батламж, үйлчилгээний тохирлын гэрчилгээ, мэргэшлийн аттестатчилал, зөвшөөрлийн цохолт, баталгаа, шинжилгээний акт, үнэлгээний акт, аккредитаци, тодорхойлолт олгож байгаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зорилт хангагдахгүй

байна гэж үзэх шүүмжлэл олон нийт болон зарим судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зорилт хийгээд Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолоор зөвшөөрлийн нийтлэг харилцаа, зөвшөөрөлтэй эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны нэгдсэн жагсаалт бий болгох зорилт хангагдаагүй, улмаар хуулийн анхлан боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэний үр дүнд хүрэх гэж байсан зорилго болох зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн нөхцөлд гадаад, дотоод хөрөнгө оруулагч, аж ахуйн эрхлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан дэмжих чиглэлээр төрийн цэгцтэй зохицуулалт хийх, төрийн байгууллагаас хүнд суртал чирэгдэлгүй уян хатан үйлчлэх, нөгөө талаас үндэсний аюулгүй байдал, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэх зорилгыг зохистой байдлаар хангахад учир дутагдалтай хэвээр байна.

Иймд үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, төрөл, тэдгээрийн бүртгэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг тогтоохтой холбоотой нийтлэг харилцааг зохицуулах байдлаар хуулийн зорилтыг авч үзэх нь чухал бөгөөд цаашид хуулийн зохицуулах харилцааг оновчтой болгох алхам байх болно.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж

2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна.

Түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр заасан байх боловч мөн хуулийн 2.3 дахь хэсэгт “Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна. “ гэж заасан нь хуулийн үйлчлэх хүрээ, зохицуулах харилцааны талаар дурдсан нь хууль техникийн хувьд алдаатай зохицуулалт болсон байна.

Нөгөө талаар Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуультай уялдуулан хянан үзэж, тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаатай үүрэг Засгийн газарт өгөгдсөн ч одоог болтол бүрэн хэрэгжээгүй байгаа анхаарч, тусгай зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг харилцааг нэг мөр зохицуулж хууль тогтоомжийн зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах алхамыг зайлшгүй хийгдэх ёстойг харуулж байна.

3.1.1.”аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад зааснаар тусгай зөвшөөрөл гэдгийг эрх бүхий байгууллагаас олгосон **баримт бичиг** гэж олгохоор томьёолсон Иргэний хуулийн зохицуулалттай нийцэхгүй хийгээд практикт хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлгүй гэж үзэхээр байна.

Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.8 дахь хэсэгт “Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ.” гэж, 189 дүгээр зүйлийн 189.2 дахь хэсэгт “Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно.” гэж, мөн зүйлийг 189.3 дахь

хэсэгт “Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.” гэж тус тус зааснаас тусгай зөвшөөрөл баримт бичиг бус тодорхой үйлдэл, үйл ажиллагаа эрхлэх **“эрх”** гэж ойлгогдохоор байна.

Түүнчлэн цаашид зөвшөөрлийг цахимаар олгох, олгосон зөвшөөрлийг цахимаар сунгах тохиолдолд “цахим гэрчилгээ” буюу “цахим код, эсхүл дугаар”-ыг олгох боломжтой буюу дээрх код, эсхүл дугаараар тухайн этгээд үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад эрх бүхий этгээд эсэхийг шалгах, нягтлах боломжтой юм.

Харин тусгай зөвшөөрлийг баримт бичиг хэмээн үзэх одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт, ойлголт дээрх боломжийг үгүйсгэсэн, иргэдэд чирэгдэл хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хүргэх, зөвшөөрөл олгох харилцаа ил тод, хяналттай буюу зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох боломжийг хаагдуулахаар байгааг анхаарах, залруулах шаардлагатай гэж үзэж байна.

Ийнхүү **“тусгай зөвшөөрөл бол баримт бичиг” гэсэн ойлголтыг засаж, залруулж “тусгай зөвшөөрөл бол эрх” гэсэн ойлголтыг бий болгох нь** Улсын Их Хурлаас 2018 оны 6 дугаар 21-ний өдөр баталж мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн үзэл баримтлал, зохицуулалттай ч нийцэх юм.

Өөрөөр хэлбэл, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Бүртгэлийг улсын бүртгэл, төрөлжсөн бүртгэл гэж ангилна.” гэж, мөн зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бусад хуульд заасан бүртгэл нь төрөлжсөн бүртгэлд хамаарах бөгөөд төрөлжсөн бүртгэлийн жагсаалтыг Засгийн газар батлах, мөн зүйлийн 5.6 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлж болно.” гэж, мөн зүйлийн 5.7 дахь хэсэгт “Бүртгэлийг цахим хэлбэрээр хөтлөхөд аюулгүй байдлыг хангасан, кодлогдсон технологийг ашиглах бөгөөд өөр хоорондоо уялдаатай, нэгдсэн стандарт, арга зүйтэй байна.” гэж, мөн зүйлийн 5.8 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн мэдээллийн сантай төрөлжсөн мэдээллийн сан мэдээлэл солилцох боломжтой байна.” нийцэж, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтой уялдах болно.

Түүнчлэн “тусгай зөвшөөрөл” гэсэн нэр томъёог авч үзэх шаардлагатай бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тухайлсан этгээдийн баталсан захиргааны хэм хэмжээний актаар иргэн, хуулийн этгээд аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгох шинжтэй харилцааг зохицуулж, зөвшөөрөл буюу эрх олгосон нотолсон баримт бичгийг олон янзаар нэршиж байна.

Тухайлбал, тусгай зөвшөөрөл, зуучлах зөвшөөрөл, дүгнэлт, зөвшөөрөл, эрхийн бичиг, зөвшөөрлийн хуудас, гэрчилгээ, эрхийн гэрчилгээ, сертификат, батламж, үйлчилгээний тохирлын гэрчилгээ, мэргэшлийн аттестатчилал, зөвшөөрлийн цохолт, баталгаа, шинжилгээний акт, үнэлгээний акт, аккредитаци, тодорхойлолт зэрэг нэршил хэрэглэгдэж байна.

Иймд дээрх ерөнхий агуулгыг илэрхийлж болох “зөвшөөрөл” гэсэн нэр томъёог хэрэглэж хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжтой гэж үзэж байна.

3.2.Практикт нийцэж байгаа байдал:

5.2.Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлээр тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээтэй холбоотой зохицуулалтыг тусгаж мөн зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар “Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.” гэж хуульчилсан боловч уг зохицуулалтын үр нөлөө, хэрэгжилт хангалттай биш байгаа нь нууц биш юм.

Дээрх зохицуулалт нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох.” гэж заасан зохицуулалттай нягт холбоотой бөгөөд өнөөдрийн байдлаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 19 чиглэлээр 103 ерөнхий төрөл, энэхүү төрөл нь 210 гаруй дэд төрөлд хуваагдан тусгай зөвшөөрөл олгохоор зохицуулалттай байна.

Монгол Улсын Засгийн газраас одоогийн эрх зүйн орчин, зөвшөөрөл олгож байгаа эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд судалгаа, хяналт шинжилгээний ажлыг хийлгэсэн байдаг бөгөөд энэ талаар Ерөнхий сайдын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 177 дугаар захирамжаар байгуулагдсан УИХ-аас бүрдсэн Ажлын хэсэг, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 172 дугаар тушаалаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын

төлөөллөөс бүрдсэн Ажлын дэд хэсэг гарч шаардлаггүй зөвшөөрлийг устгах өргөн далайцтай хэлэлцүүлгийг 2013 оны 10 дугаар сараас 2014 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нэг бүрийн төлөөллийг оролцуулан явуулж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох нэгдсэн санал дүгнэлт, ойлголцолд хүрсэн байдаг.

Дээрх хэлэлцүүлэг, судалгаа, хяналт шинжилгээний үр дүнгээр 43 байгууллагаас олгодог, 881 зөвшөөрөлд⁹ дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байдаг ба Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар олгогдож байгаа тусгай зөвшөөрөл 293, бусад хууль тогтоомжоор олгохоор заасан зөвшөөрөл 353, эрх, гэрээ зэрэг төрийн байгууллагад бүртгэгдвэл зохих бүртгэл хэлбэрээр 30, гэрчилгээ, түүнийг олгох, зарим гэрээ байгуулах хэлбэрээр 140, төрийн байгууллагаас гарган өгч байгаа лавлагаа, тодорхойлолт хэлбэрээр 19, тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналт зэрэг холбогдох төрийн байгууллагын санал авах хэлбэрээр зөвшөөрөл 39 байна гэж дүгнэсэн байдаг.

Дээрх судалгааны дүн нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлээр тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээтэй холбоотой зохицуулалтыг тусгаж мөн зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар “Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай болон мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох.” зарчим, зохицуулалт хэрэгжихгүй, улмаар тусгай зөвшөөрлийн талаарх нэгдсэн ойлголт, бодлого байхгүй, аливаа зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, үнэлгээ хийх зарчмыг баримталдаггүйг илтгэж байна.

Мөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан зохицуулалт, зарчим гажуудах, алдагдах нөхцөлийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрээр бүрдүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

⁹ “зөвшөөрөл” гэдэгт дүгнэлт, зөвшөөрөл, шийдвэр, гэрчилгээ, сертификат, батламж, үйлчилгээний тохирлын гэрчилгээ, мэргэшлийн аттестатчилал, зөвшөөрлийн цохолт, баталгаа, шинжилгээний акт, үнэлгээний акт, аккредитаци, тодорхойлолт, хамтран ажиллах гэрээ зэрэг хэлбэрээр аж ахуйн нэгжид тодорхой төрлийн үйлдэл, үйл ажиллагаа явуулах эрхийг зохих эрх бүхий байгууллагаас олгож байгааг баталгаажуулсан, эсхүл энэхүү эрхийг олгох урьдчилсан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхийг нотолсон баримт бичгийг хамруулан ойлгосон байдаг.

Өөрөөр хэлбэл хууль давсан, хуульд байхгүй зөвшөөрлийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрээр бий болгох үзэгдэл нэлээдгүй байна. Тухайлбал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн тогтоолоор “Соёл урлагийн төлбөрт үйлчилгээний журам”¹⁰-ыг баталж, караоке ажиллуулах, диско үйлчилгээ үзүүлэх, соёл урлагийн мэргэжлийн сургалт явуулахад тус тус зөвшөөрөл олгохоор зааж, хуульд зааснаас бусад бичиг баримт шаардах, хуулиар тогтоогоогүй төлбөр, хураамж болох 60000 төгрөг, 250000 төгрөг, 150000 төгрөгийн үйлчилгээний хурамаажийг иргэн, хуулийн этгээдээс авч байна.

Дээрх тоо баримт, жишээ нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь үзэл баримтлалыг гажуудуулсан, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг чөлөөтэйгээр эрхэлж болох боломжийг бусад хууль тогтоомж, захиргааны хэмжээгээр алдагдуулсан, нөгөө талаар худалдаа, бизнесийн үйл ажиллагаа өргөжих, хөгжих нөхцөл бүрдэхэд ихээхэн дарамт учруулж байна гэж үзэхээр байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсад ямар үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр эрхлэдэг, ямар үйл ажиллагааг эрхлэхийг хориглодог талаар нэгдсэн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байгааг харуулж байна.

9.1.Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараахь зарчмыг баримтална:

9.1.4.зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн зааснаар тусгай зөвшөөрлийг олгохдоо баримтлах зарчмын нэг нь зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох гэж тодорхойлсон байна.

Дээр дурдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар олгогдож байгаа тусгай зөвшөөрөл 293, бусад хууль тогтоомжоор олгохоор заасан зөвшөөрөл 353, эрх, гэрээ зэрэг төрийн байгууллагад бүртгэгдвэл зохих бүртгэл хэлбэрээр 30, гэрчилгээ, түүнийг олгох, зарим гэрээ байгуулах хэлбэрээр 140, төрийн байгууллагаас гарган өгч байгаа лавлагаа, тодорхойлолт хэлбэрээр 19, тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналт зэрэг холбогдох төрийн байгууллагын санал авах хэлбэрээр зөвшөөрөл 39 байна гэсэн судалгаанаас үзэхэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиас гадна салбарын бусад хуулиар тусгай зөвшөөрлийн төрлийг шинээр бий болгох, цаашилбал хуулиас

¹⁰ <https://eservice.ulaanbaatar.mn/#/service/detail/s105>

давсан захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрлийг төрлийг бий болгодог практик тогтсон байна.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад хуулиар олгохоор заасан зөвшөөрлийн төрлийн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар задалж олгох хууль зүйн практик ч мөн тогтсоныг залруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэхээр байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар өнөөдрийн байдлаар олгож байгаа тусгай зөвшөөрлийг чиглэл, төрлийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1

15.1.Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

15.2.Банкны үйл ажиллагааны чиглэлээр:

15.2.1.банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх.

15.3.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

15.3.1.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.2.арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.3.3.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.4.банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.5.үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх;

15.3.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;

15.3.7.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.8.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх;

15.3.9.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх.

15.4.Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

15.4.1.нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.2.аудитын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.3.үнэт цаас үйлдвэрлэх;

15.4.4.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах;

15.4.7.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.4.8.гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх;

15.4.9.хөрөнгийн үнэлгээ хийх;

15.4.10.татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх.

15.5.Хууль зүйн чиглэлээр:

15.5.1.нотариатын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.2.галт зэвсэг, сум импортлох, нийтэд худалдах;

15.5.3.галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл үйлдвэрлэх;

15.5.4.галт зэвсгийн сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх;

15.5.5.галт зэвсгийн сум импортлох, нийтэд худалдах;

15.5.6.галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.7.хуулийн этгээд харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.8.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.9.тамга, тэмдэг үйлдвэрлэх.	
15.6.Байгаль орчны чиглэлээр:	
15.6.1.озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;	
15.6.2.тэсэрч, дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх;	
15.6.3.тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах;	
15.6.5.стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;	
15.6.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх;	
15.6.7.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх.	
15.7.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:	
15.7.1.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх;	
15.7.2.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;	
15.7.3.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;	
15.7.4.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах;	
15.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх;	
15.7.6.мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах;	
15.7.7.гадаад улсад боловсрол эзэмшүүлэх, сургалтад хамруулахад зуучлах үйлчилгээ;	
15.7.8.олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийг байгуулах;	
15.7.9.гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах;	
15.7.10.соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх.	
15.8.Түлш, эрчим хүчний чиглэлээр:	
15.8.2.эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах;	
15.8.3.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;	
15.8.5.зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх.	
15.9.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:	
15.9.1.гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар иргэдэд зуучлах үйлчилгээ эрхлэх.	
15.10.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:	
15.10.2.үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх;	
15.10.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, худалдах үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах;	
15.10.5.ашигт малтмалын хайгуул хийх;	
15.10.6.ашигт малтмал ашиглах;	

15.10.12.согтууруулах ундаа импортлох;
 15.10.13.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;
 15.10.14.тамхи импортлох;
 15.10.15.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх;
 15.10.16.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх;
 15.10.17.бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх;
 15.10.18.газрын тос хайх;
 15.10.19.уламжлалт бус газрын тос хайх;
 15.10.20.газрын тос ашиглах;
 15.10.21.уламжлалт бус газрын тос ашиглах;
 15.10.22.үүсмэл орд ашиглах.

15.11.Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:
 15.11.1.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх;
 15.11.2.сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх;
 15.11.3.таримал ургамлын үр үйлдвэрлэх;
 15.11.4.малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;
 15.11.6.ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;
 15.11.7.шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх, мал, үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах;

15.12.Эрүүл мэндийн чиглэлээр:
 15.12.2.хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох;
 15.12.3.эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;
 15.12.4.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох, экспортлох;
 15.12.6.өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;
 15.12.8.ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх;
 15.12.9.биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх;
 15.12.11.улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.

15.13.Зохиогчийн эрх, патентын чиглэлээр:
 15.13.1.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах.

15.14.Барилга, хот байгуулалтын чиглэлээр:
 15.14.3.цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;
 15.14.5.нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.6.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

15.14.7.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх.

15.15.Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр:

15.15.1.төмөр замын суурь бүтэц барих, ашиглах;

15.15.2.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

15.15.3.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;

15.15.4.автозам, замын байгууламжийг барих, засварлах;

15.15.4.авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

15.15.5.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

15.15.9.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.15.11.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

15.15.12.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх.

15.16.Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

15.16.1.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

15.16.2.харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;

15.16.3.контентийн үйлчилгээ эрхлэх;

15.16.4.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох.

15.17.Стандарчлал, хэмжил зүйн чиглэлээр:

15.17.1.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах.

15.18.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр:

15.18.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.18.2.цөмийн төхөөрөмж ашиглах;

15.18.3.цөмийн бодис эзэмших, ашиглах;

15.18.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;

15.18.5.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;

15.18.6.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;

15.18.7.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх;

15.18.8.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

15.19.Батлан хамгаалах чиглэлээр:

15.19.1.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг экспортлох, импортлох;

15.20.Гамшгаас хамгаалах чиглэлээр:

15.20.1.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл

16.1.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага тусгай зөвшөөрөл олгоно:

16.2.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.2.2.эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

16.2.4.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;

16.2.5.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;

16.2.6.эмчилгээний гоо заслын үйлчилгээ;

16.2.7.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.

16.3.Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.3.1.агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;

16.3.4.тамхи худалдах.

16.4.Чөлөөт бүсийн захирагч нь энэ хуулийн 16.2.2, 16.2.5, 16.2.6, 16.3.4-т заасан тусгай зөвшөөрлийг олгоно.

Жишээ 1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт банкны үйл ажиллагааны чиглэлээр олгох зөвшөөрлийг төрлийг заасан байх бөгөөд мөн зүйлийн 15.2.1 дэх заалтад зааснаар -банк байгуулах, -банкны үйл ажиллагаа эрхлэх гэж 2 төрлийн зөвшөөрлийг олгохоор байна.

Гэтэл Улсын тэмдэгтийн хураамуийн тухай хуулийн 17 дугаар зүйлээр дээрх 2 төрлийн зөвшөөрлийг 16 болгон задалж хууль хоорондын зөрчлийг үүсгэсэн гэж үзэхээр байна. Тус хуульд зааснаар банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 480 000-1 200 000 төгрөг; мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах тусгай зөвшөөрөл, гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл, үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл, үнэт зүйл хадгалах тусгай зөвшөөрөл, гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл, гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл, гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл болон хууль тогтоомжоор хориглоогүй, **Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил,**

үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр заасан байна.

Түүнчлэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.16 дахь заалтад “хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 52 000-130 000 төгрөг.” гэж заасан зөвшөөрлийг зөвхөн хуулиар бий болгох, хуульд заасан тохиолдолд олгох суурь зарчмыг алдагдуулахын зэрэгцээ хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь үзэл баримтлалыг гажуудуулж буйн нэгээхэн жишээ гэж хэлж болохоор байна.

Жишээ 2 Мөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх заалтад заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар 26 зөвшөөрөл, бүртгэл болгон задалж буюу

- зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
- гадаад валютын үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- итгэлцлийн үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл
- банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл
- үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, бүртгэх
- үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тусгай зөвшөөрөл
- үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл
- үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл
- андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл

-хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл
-барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
-хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор хууль хоорондын уялдааг алдагдуулсан байна.

Жишээ 3 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.9 дэх заалтад заасан усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар дунд оврын хөлөг онгоцын зөвшөөрөл; бага оврын усан онгоцын зөвшөөрөл, жижиг оврын моторт завины үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл гэж 3 ангилж, улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр заасан байна.

Энэ нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дээрх зохицуулалт /29.1.9.а, 29.1.9.б, 29.1.9.в дэд заалт/ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.9 дэх заалттай зөрчилдөхөөс гадна Усан замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Усан замын тээврийн хэрэгслийг жижиг /таван метр хүртэл урттай, дөрвөөс ихгүй хүний суудалтай/, бага /таваас хорин метр хүртэл урттай, арван хоёроос ихгүй хүний суудалтай/, дунд /хориос тавин метр хүртэл урттай/, **том оврын /тавин метр, түүнээс илүү урттай/ гэж** ангилна.” гэж заасантай буюу том оврын усан замын тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа явуулах этгээд зөвшөөрөл олгох эсэхийг тодорхой бус болгож, нөгөөтэйгүүр тэдгээр этгээдэд давуу тал болох зохицуулалт болсон байна.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага тусгай зөвшөөрөл олгоно.” гэж заасан хэдий ч 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар дээрх хэсгийн заалтыг хүчингүй болгосон бөгөөд хуулийн зөрчил, хийдэл болон өдийг хүртэл үйлчилж байна.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын олгох тусгай зөвшөөрлийг заасан байх боловч практикт нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрээр тусгай зөвшөөрлийг бий болгох, төлбөр хураамж авах зэрэг хууль харшилдсан үзэгдэл түгээмэл байна.

Тухайлбал, соёл, урлагийн болоод нэгдсэн үйл ажиллагаа зохион байгуулахад тохиромжтой 7х8 хэмжээтэй тайз, бүх төрлийн хөгжим, техник аппаратур бүхий явуулын тайзтай автомашины тусгай зөвшөөрлийг нийслэлийн Засаг даргын тамгын газраас олгодог бөгөөд үйлчилгээний хурамааж нь 1,000,000 төгрөг авдаг байна.

Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн хэрэгжилтийн хэсгийг харах. /хуудас 14/

Дээрх жишээнүүдээс үзэхэд “Зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох” гэж томъёолсон нь хангалттай зохицуулалт байж чадахгүй гэдгийг өнөөдрийн хууль, эрх зүйн орчин харуулж байгаа бөгөөд **“энэ хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох”** гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд хуульчилж, зөвшөөрлийн нэгдсэн жагсаалтыг бий болгох шаардлагатайг харуулж байна.

Ингэснээр бусад салбарын, эсхүл татварын хуулиар шинээр зөвшөөрлийг бий болгодог, эсхүл хуулиас давсан эрх зүйн хэм хэмжээний актаар зөвшөөрлийг бий болгодог харилцааг таслан зогсоож чадна гэж дүгнэж болно.

Улмаар хариуцлагын механизмыг дээрх зохицуулалттай уялдуулах шаардлагатай бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглох, түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болохоор хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал:

18 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Зөрчлийн тухай хуульд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль зөрчих зөрчлийг тухайлан заагаагүй боловч Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйл буюу Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих зөрчлийг тусгасан байна.

Өөрөөр хэлбэл Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Зөвшөөрөлтэйгөөр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус заасан байна.

Харин тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хасгаалсан заалтыг Зөрчлийн тухай хуулийн 10.27 дугаар зүйл буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах гэсэн зүйлд тусгасан байх бөгөөд мөн зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ

хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байна.

Түүнчлэн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил тус бүр дээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой зөрчлийг хуульчлан тусгасан байна. Тухайлбал 5.6 дугаар зүйл буюу Хууль бусаар зэвсэг эзэмших гэсэн зөрчил тусгагдсан байх бөгөөд тусгай зөвшөөрөлгүйгээр галт зэвсэг, сум импортолсон, худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн галт зэвсэг, сумыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байна.

Түүнчлэн 5.11 дүгээр зүйл буюу Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих зөрчил тусгагдсан бөгөөд мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж хуульчилжээ.

Галын аюулгүй байдлын тухай хууль зөрчих буюу Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтад “галын аюултай материал хадгалах, ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахдаа эрх бүхий байгууллагын мэргэжлийн дүгнэлт гаргуулах, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, Хог хаягдлын тухай хууль зөрчих буюу 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн амын төвлөрсөн суурьшлын бүс, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц тогтоогдсон газарт зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар хориглосон бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 6.7 дахь заалтад “хадгалахад эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авахаар заасныг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих буюу 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн заагт зөвшөөрөлгүй нэвтэрч хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Ус хангамж, ариутгах татуургын барилга

байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж, шугам сүлжээ барьсан бол түүнийг буулгаж, үйл ажиллагааг зогсоож учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсэгт “Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарьсан, эсхүл бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавж, мэрэгчийг устгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн нэг удаагийн шинжтэй зөвшөөрөлтэй холбоотой зөрчилд оногдуулах зөрчлийг хуульчилсан байна. Тухайлбал, Гаалийн тухай хууль зөрчих буюу Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт **“Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлгөсөн,** эсхүл ачсан, эсхүл буулгасан, эсхүл шилжүүлэн ачсан нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Гаалийн хяналтад байгаа барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй олгосон, гаалийн хилээр гаргасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Гаалийн зорилгоор хийх тэмдэглэгээг гэмтээсэн, өөрчилсөн, устгасан, эсхүл гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн хүрэх газрын хаягийг өөрчилсөн нь барааг хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоогүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, **Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчих буюу Зөрчлийн тухай хуулийн 11.22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хорио цээрийн хяналт, шалгалтын үед амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгасан** бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус хуульчлан хэрэгжүүлж байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйл буюу Тамхины хяналтын тухай хууль зөрчих, 6.4 дүгээр зүйл буюу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих, 6.5 дугаар зүйл буюу Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих, 6.6 дугаар зүйл буюу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих, 6.7 дугаар зүйл буюу Эрүүл мэндийн тухай хууль зөрчих, 6.9 дүгээр зүйл буюу Дархлаажуулалтын тухай хууль зөрчих, 6.10 дугаар зүйл буюу Донорын тухай хууль зөрчих, 6.14 дүгээр зүйл буюу Хүнсний тухай хууль зөрчих, 6.15 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих, 7.3

дугаар зүйл буюу Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих, 7.4 дүгээр зүйл буюу Агаарын тухай хууль зөрчих, 7.6 дугаар зүйл буюу Амьтны тухай хууль зөрчих, 7.7 дугаар зүйл буюу Байгалийн ургамлын тухай хууль зөрчих, 7.9 дүгээр зүйл буюу Ойн тухай хууль зөрчих, 7.11 дүгээр зүйл буюу Ашигт малтмалын тухай хууль зөрчих, 7.12 дугаар зүйл буюу Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих, 7.13 дугаар зүйл буюу Газрын тосны тухай хууль зөрчих, 7.14 дүгээр зүйл буюу Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих, 7.15 дугаар зүйл буюу Усны тухай хууль зөрчих, 7.16 дугаар зүйл буюу Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих, 8.1 дүгээр зүйл буюу Газрын тухай хууль зөрчих, 8.2 дугаар зүйл буюу Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих, 9.1 дүгээр зүйл буюу Боловсролын тухай хууль зөрчих, 9.3 дугаар зүйл буюу Дээд боловсролын тухай хууль зөрчих, 9.7 дугаар зүйл буюу Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих, 10.7 дугаар зүйл буюу Өрсөлдөөний тухай хууль зөрчих, 10.13 дугаар зүйл буюу Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль зөрчих, 10.18 дугаар зүйл буюу Инновацийн тухай хууль зөрчих, 10.22 дугаар зүйл буюу Цахим гарын үсгийн тухай хууль зөрчих, 10.23 дугаар зүйл буюу Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль зөрчих, 10.24 дүгээр зүйл буюу Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль зөрчих, 11.1 дүгээр зүйл буюу Аудитын тухай хууль зөрчих, 11.3 дугаар зүйл буюу Банкны тухай хууль зөрчих, 11.5 дугаар зүйл буюу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зөрчих, 11.6 дугаар зүйл буюу Санхүүгийн үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх, 11.9 дүгээр зүйл буюу Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль зөрчих, 11.10 дугаар зүйл буюу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зөрчих, 11.11 дүгээр зүйл буюу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль зөрчих, 11.12 дугаар зүйл буюу Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль зөрчих, 11.13 дугаар зүйл буюу Даатгалын тухай хууль зөрчих, 11.14 дүгээр зүйл буюу Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль зөрчих, 11.15 дугаар зүйл буюу Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих, 11.20 дугаар зүйл буюу Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль зөрчих, 11.26 дугаар зүйл буюу Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль зөрчих, 11.27 дугаар зүйл буюу Хөрөнгийн үнэлгээний тухай хууль зөрчих, 11.28 дугаар зүйл буюу Валютын зохицуулалтын тухай хууль зөрчих, 11.30 дугаар зүйл буюу Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль зөрчих, 12.1 дүгээр зүйл буюу Барилгын тухай хууль зөрчих, 12.2 дугаар зүйл буюу Геодези, зураг зүйн тухай хууль зөрчих, 12.3 дугаар зүйл буюу Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль зөрчих, 12.4 дүгээр зүйл буюу Орон сууцны тухай хууль зөрчих, 12.5 дугаар зүйл буюу Хот байгуулалтын тухай хууль зөрчих, 12.8 дугаар зүйл буюу Эрчим хүчний тухай хууль зөрчих, 12.11 дүгээр зүйл буюу Цөмийн энергийн тухай хууль зөрчих, 13.1 дүгээр зүйл буюу Тариалангийн тухай хууль зөрчих, 13.4 дүгээр зүйл буюу Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль зөрчих, 13.6 дугаар зүйл буюу Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль зөрчих, 14.1 дүгээр зүйл буюу Харилцаа холбооны тухай хууль зөрчих, 14.2 дугаар зүйл буюу Радио долгионы тухай хууль зөрчих, 14.4 дүгээр зүйл буюу Авто замын тухай хууль зөрчих, 14.5 дугаар зүйл буюу Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах, 14.6 дугаар зүйл буюу Автотээврийн тухай хууль зөрчих, 14.8 дугаар зүйл буюу Иргэний нисэхийн

тухай хууль зөрчих, 14.10 дугаар зүйл буюу Төмөр замын тээврийн тухай хууль зөрчих, 16.1 дүгээр зүйл буюу Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих гэсэн нийт **74 зүйл дээр** тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомж, журам зөрчсөн иргэд, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгагдсан байна.

Эрүүгийн хуулийн **Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг хэсгээх Арван тавдугаар бүлэгт Хууль бусаар үр хөндөх буюу 15.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт** “Эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ **үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй эмч эмнэлгийн бус нөхцөлд; тусгай зөвшөөрөлгүй хүн хууль бусаар үр хөндсөний** улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж хуульчилсан байна.

Түүнчлэн Эдийн засгийн гэмт хэргийн бүлэгт Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах буюу 18.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар банкныг **эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нээж үйл ажиллагаа явуулсан**, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг хууль бусаар бүрдүүлсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр, **Үндэсний төлбөрийн системд холбогдох үйл ажиллагаа хууль бусаар эрхлэх буюу 18.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт** зааснаар үндэсний төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар эрхэлсэн бол нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр, **Хууль бусаар дампууруулах буюу 18.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт** зааснаар дампууруулах ноцтой үндэслэл бий болоогүй байхад хүчээр, хууран мэхэлж, гарцаагүй байдалд оруулж дампууруулсан; хуулийн этгээдийн талаар хуурамч мэдээлэл тарааж, гүтгэж, зориуд өр төлбөрөө өгөхгүй байж дампуурахад хүргэсэн; төрийн албан хаагч төрөөс үзүүлэх ёстой үйлчилгээг хуулийн дагуу үзүүлээгүй, зохих ёсоор бүртгээгүй, тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцалсан, үндэслэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож олгосны улмаас хуулийн этгээд дампуурсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заасан нь тусгай зөвшөөрөлгүйгээр зарим төрлийн үйл ажиллагаа явуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох, **тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцалсан, үндэслэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож олгосны улмаас** хуулийн этгээд дампуурсан бол мөн гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон байна.

Эрүүгийн хуулийн 19.17 дугаар зүйл /Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх/-ийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын

хилийн тэмдэг, тэдгээрийн холбоос, хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн, хил дамнасан байгууламжийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр устгасан, гэмтээсэн, шилжүүлсэн; улсын хилийн усны гольдролыг өөрчилсөн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 20.13 дугаар зүйл /Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах/-ийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, эсхүл батлагдсан зураг төслөөс өөрөөр, эсхүл чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, ашиглалтад оруулсны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 20.14 дүгээр зүйл /Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх/-ийн 1 дэх хэсэгт “Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, малын эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, худалдсан, түгээсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр явуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тус тус хуульчлан заажээ.

Мөн Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйл /Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах /-ийн 1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолоодох эрхийн үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр байна.

Эрүүгийн хуулийн Хорин дөрөвдүгээр бүлэг буюу Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн бүлгийн 24.2 дугаар зүйл буюу Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйлдлийг гэмт хэрэгт тооцон хариуцлагажуулсан байна.

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрөлтэйгээр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.” гэж тус тус хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 24.4 дүгээр зүйл /Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах/-ийн 1 дэх хэсэгт “Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бусаар олж авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, экспортолсон, импортолсон, худалдсан, түрээслэсэн, тээвэрлэсэн, боловсруулсан, үйлдвэрлэсэн, булшилсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.” гэж, 24.5 дугаар зүйл /Хууль бусаар ан агнах/-ийн 1 дэх хэсэгт “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл

хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 24.6 дугаар зүйл /Хууль бусаар мод бэлтгэх/-ийн 1 дэх хэсэгт “**Зөвшөөрөлгүйгээр** ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 24.8 дугаар зүйл /Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх/-ийн 1 дэх хэсэгт “**Зохих зөвшөөрөлгүйгээр**, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 24.9 дүгээр зүйл /Байгалийн тэнцэл алдагдуулах/-ийн 1 дэх хэсэгт “Амьтан, ургамлын зүйлийг **зөвшөөрөлгүйгээр** гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 27.7 дугаар зүйл /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/-ийн 1 дэх хэсэгт “**Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зөвшөөрөлгүй** арилжааны нислэг үйлдсэн, заасан маршрутыг зөрчиж ниссэн, агаарын зам, буух газрыг дур мэдэн өөрчилсөн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж зарим үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлгүйгэр эрхлэх нь гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилсан байна.

Дөрөв.Зөвлөмж

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнээс үзэхэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуулийн зохицуулалтын зөрчил, хийдлээс шалтгаалан бусад салбарын хууль, татварын хууль тогтоомж хийгээд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг бий болгох, татвар хураамж тогтоож иргэд, хуулийн этгээдэд хүндрэл, бэрхшээл үүсгэж байна. Түүнчлэн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лицензийн тоог цөөлж, тэдгээрийг авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох шаардлагатай гэдэг харагдаж байна.

Иймд тус хуулийг нийгмийн харилцааны өөрчлөлт, эдийн засаг, бизнесийн харицлаг дэмжих, эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн бүхэлд нь шинэчлэх шаардлагатай бөгөөд дараахь асуудлыг хамруулах нь зүйтэй байна:

1.Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугар тогтоолд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуультай уялдуулан хянан үзэж, тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаатай үүрэг Засгийн газарт өгөгдсөн ч одоог болтол бүрэн хэрэгжээгүй байгааг анхаарч, **тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн нэгдсэн жагсаалтыг бий болгож**, бусад салбарын, эсхүл татварын хуулиар шинээр зөвшөөрлийг бий болгодог, эсхүл хуулиас давсан эрх зүйн хэм хэмжээний актаар зөвшөөрлийг бий болгодог практикийг халахад анхаарах;

2.Үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, төрөл, тэдгээрийн бүртгэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг тогтоохтой холбоотой нийтлэг харилцааг зохицуулах байдлаар хуулийн зорилтыг өргөжүүлэх;

3.“тусгай зөвшөөрөл бол баримт бичиг” гэсэн ойлголтыг засаж, залруулж “тусгай зөвшөөрөл бол эрх” гэсэн ойлголтыг бий болгоход анхаарах;

4.Зөвшөөрөлтэйгээр эрхлэхээр олгосон нэг удаагийн болон олон удаагийн шинжтэй бүх зөвшөөрлийн бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан зөвшөөрлийн цахим нэгдсэн сантай байх ба зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бий болгох;

5.Хуулийн нэр хийгээд хуулийн зорилтод тусгаж хэрэглэсэн “тусгай зөвшөөрөл” гэх ойлголт хэт явцуу байдалтай байгаа бөгөөд өнөөдөр практикт зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх эрхийг зохих эрх бүхий байгууллагаас олгож байгааг баталгаажуулсан, эсхүл энэхүү эрхийг олгох урьдчилсан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхийг нотолсон баримт бичгүүд болох, нэршлийн хувьд дүгнэлт, зөвшөөрөл, шийдвэр, гэрчилгээ, сертификат, батламж, үйлчилгээний тохирлын гэрчилгээ, мэргэшлийн аттестатчилал, зөвшөөрлийн цохолт, баталгаа, шинжилгээний акт, үнэлгээний акт, аккредитаци, тодорхойлолт зэргээр олгож байгааг анхаарч тэдгээрийг нэг мөр илэрхийлэх нэр томъёогоор томъёолох;

6.Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглож, хариуцлагыг хуульчлах;

7.Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон этгээд хариуцахаар тусгах;

8.Засгийн газар үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Засгийн газар, түүний харьяа байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдээс олгодог зөвшөөрөлийг олгох, сунгах үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийх зохицуулалтыг тусгах;

9.Хуульд заасан тохиолдолд зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг хөнгөвчилсөн/хялбаршуулсан горимоор явуулах, зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

10.Зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзах;

11.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад анхаарах төдийгүй зөвшөөрлийн тоог цөөн байхад анхаарах бус түүнийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам тодорхой, нээлттэй, олгогдсон зөвшөөрлийн мэдээллийн сан нээлттэй байх боломжийг бүрдүүлэх.